



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар А/39

Батноров сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. XVII дугаар жарны “Элдэв эрдэнэт” хэмээх Модон Могой жилийн сар шинийн баярыг тохиолдуулан Сар шинийн үндэсний бөхийн барилдааныг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Л.Амармэнд (Санхүү албаны дарга)
Нарийн бичгийн дарга:	Ж.Ариунбаяр (Байгаль хамгаалагч)
	Ц.Тайванхүү (Биеийн тамирын арга зүйч)
Гишүүд:	Э.Баяртулга (6-р багийн Засаг дарга)
	Т.Даваажав (2-р багийн Засаг дарга)
	П.Саранзаяа (Соёлын төвийн дарга)
	Б.Энхжаргал (Нягтлан бодогч)
	Г.Пүрэвсүрэн (Нярав)
	Б.Баасанжав (Нийгмийн даатгалын байцаагч)

2. Сар шинийн үндэсний бөхийн барилдааны бэлтгэлийг бүрэн хангаж, холбогдох дүрэм, журмын дагуу зохих шаардлагуудыг тавьж чанартай зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Амармэнд)-д даалгасугай.

ДАРГА  ГОТГОНБАЯР

230425115